



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

Өдөрлөг зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулах “Эрүүл агаар-Эрч хүч” сэдэвт спорт өдөрлөгийг 2017 оны 03 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын баг /Ч.Баттулга/, Эмнэлгийн тоног, төхөөрөмжийн алба /Д.Тамир/-д тус тус даалгасугай.

2. Спорт өдөрлөгийн удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Уг арга хэмжээнд шаардагдах төсвийг зохих зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү, үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.НАРАНТУЯА



Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын 2017 оны 03 дугаар сарын 10 ны өдрийн 131 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



### СПОРТ ӨДӨРЛӨГИЙН УДИРДАМЖ

**Зорилго:** Хамт олны эв нэгдлийг бэхжүүлэх, ажиллагсдын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, тэдний авхаалж самбааг сорих зорилгоор “ЭРҮҮЛ АГААР- ЭРЧ ХҮЧ спортын арга хэмжээг зохион байгуулах

**Зохион байгуулагч:** ЭТТА, ХШУДАБ, Спорт хамтлаг  
**Явагдах газар:** “Чингисийн хүрээ” амралтын газар  
**Явагдах хугацаа:** 2017 оны 03-р сарын 11-нд  
**Хамрах хүрээ:** “Эрүүл мэндийн хөгжлийн төв”-ийн ажилтан албан хаагчид

### ХӨТӨЛБӨР

Хугацаа	Хийгдэх үйл ажиллагаа	Хариуцах хүн	Тайлбар
09:00-09:30	Цугларах “Драмын театр”	Алба тус бүр	Албад ирцээ бүрдүүлэх
09:30-10:30	Амралтын газар хүрэх “Чингисийн хүрээ”		
10:30-10:45	Байрлах	Алба тус бүр	
10:45-11:15	Үдийн цай	Алба тус бүр	
11:15-12:15	Өглөөний дасгал	Ч.Баттулга, Л.Бор, С.Лхагвасүрэн	
12:15-12:30	Нээлтийн арга хэмжээ, зураг авахуулах	Б.Нарантуяа	Захирал нээж үг хэлнэ
12:30-13:30	Албадын мэндчилгээ	Ч.Баттулга, Д.Тамир	
13:30-14:30	Буухиа тэмцээн	Б.Ганчулуун, Ш.Солонго, Б.Батцоож	Албаны 2 эрэгтэй 2 эмэгтэй оролцоно. Эрэгтэй тамирчин байхгүй бол бусад албанаас оролцуулж болно.
14:30-15:30	Өдрийн хоол	Бүх ажилчид	
15:30-18:00	Чөлөөт цаг	Бүх ажилчид	
18:00	Буцах		

**Зохион байгуулагдах тэмцээн:**

- Тэнцвэр “Шил тулж доороо 10 эргээд бөмбөг өшиглөж тэмдэглэсэн цэг дээр очих  
(Багийн нэг гишүүн)
- Ууттай үсрэх “Тамирчин уутанд ороод тэмдэглэсэн цэгт үсэрч очих.”  
(Багийн нэг гишүүн)
- Шаар хагалах “Багийн хоёр гишүүн биеэрээ шаарыг шахаж хагална”.  
(Багийн хоёр гишүүн)
- Гараараа гүйх “Багийн нэг гишүүн нөгөө гишүүнийхээ хөлийг өргөөд хөлөө өргүүлсэн гишүүн нь гараараа явж тэмдэглэсэн цэгт хүрэх”.  
(Багийн хоёр гишүүн)

Багийн эхний гишүүн шил тойрч эргэхэд цагийг харж сүүлийн гишүүн гараарай гүйж орж ирэхэд цагийг зогсооно.

*Жич:*

- *Хувийн унаагаар явахгүй байх*
- *Цагтаа хөдлөх тул цагаа барих*
- *Албад ирцээ бүрдүүлэх.*
- *Шилдэг ширээг шалгаруулах тул ширээ засах хоол хүнсээ бэлтгэж ирэх.*
- *Мэндчилгээ, тэмцээн, ширээ засалтаар шилдэг албыг шалгаруулна.*


Хянасан:

Боловсруулсан:

Ч.Баттулга /ХШУДАБ-ийн ахлагч/

Б.Санж-Очир /ЭТТА-ны мэргэжилтэн/

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий  
захирлын 2017 оны 03 дугаар сарын 10 ны  
өдрийн 4/31 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**ТӨСӨВ**

№	Зориулалт	Тоо ширхэг	Үнийн дүн
1	Өдөрлөгийн үйл ажиллагааны зардалд	-	1,940,000
2	Автобусны зардалд /очих, буцах/	2	360,000
	<b>Нийт</b>		<b>2,300,000</b>